



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А103

Хажуу шинэ-Ус

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улс Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17 дугаар зүйл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 47 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын А/01 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалал" аливаа хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн амьдрах, сурч хөгжих, хүмүүжих ая тухтай орчныг бий болгох зорилгоор 2024 оныг "Хүүхэд гэр бүл хөгжил хамгаалал"-ын жил болгон зарласантай холбоотойгоор ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хэсгийн ахлагч: Б.Даваасүрэн (Засаг даргын орлогч)  
Нарийн бичгийн дарга: Н.Болор-Эрдэнэ (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)  
Гишүүд: Э.Золжаргал (Сургуулийн нийгмийн ажилтан)  
Г.Мөнхсоёл (Цэцэрлэгийн арга зүйч)  
Б.Учрал (Эрүүл мэндийн төвийн нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Х.Энхтуяа (Номын санч)

2."Хүүхэд гэр бүл хөгжил хамгаалал"-ын жилийн ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг иргэд, аж ахуйн нэгж, олон нийтэд уриалсугай.

3."Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилт үр дүнг цаг хугацаанд нь тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Н.Болор-Эрдэнэ)-д, Удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Даваасүрэн) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Т.АРИУНАА

482301001